



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/247

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах, хаягийн
Өөрчлөлтийг бүртгэх, агуулахыг нэмэлтээр
бүртгэх, тусгай зөвшөөрөл олгохгүй тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.10, 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 16, 19, 3.2 дугаар зүйлийн 1.1, 5.2 дугаар зүйлийн 11, 8.1 дүгээр зүйлийн 13.18, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, 4 дүгээр зүйлийн 4.3, 7 дугаар зүйлийн 7.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.2, 19.18, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Эрүүл мэндийн сайдын 2022 оны "Тусгай зөвшөөрөл олгох комиссын бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай" А/467 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл болон мансууруулах сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн утгар бодис, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 14 дүгээр хурлын шийдвэрийн дагуу Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах байгууллагын жагсаалтыг нэгдүгээр, тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд нэмэлтээр агуулах бүртгэх байгууллагын жагсаалтыг хоёрдугаар, төсөл дэмжигдээгүй, тусгай зөвшөөрөл олгохгүй байгууллагын жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагыг арга зүйгээр хангаж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар (Л.Зэндмаа), Чанарын хяналтын газар (Г.Номин)-т тус тус үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (П.Мөнхжаргал)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *Ш. Энхтуяа* Ш.ЭНХТУЯА



1423 010247


Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 2023
оны 12 дүгээр сарын 04 -ны
өдрийн 1247 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА СУНГАХ БАЙГУУЛЛАГУУД

№	Байгууллагын нэр /РД/	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил	Хүчинтэй хугацаа
1.	ЖЭЙ ЭМ БИ ХХК РД: 5178436 9011123142	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	СБД, 1-р хороо, Энхтайвангийн өргөн чөлөө, Фламинго цамхаг, 10/4	2028.12.14
2.	ГОО ҮЗЭСГЭЛЭН ХХК РД: 2149974 9011034150	Эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	СБД, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Алтай констракшн 3 давхар	2028.12.14
3.	САНЧИР-УНДРАХ ХХК РД: 5177022 9011119108	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	ХУД, 10-р хороо, Буянт-Ухаа 0 гудамж, ХД-39/А	2028.12.04
4.	ТАВИН-УС ХХК РД: 2541963 9011120054	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	ЧД, 2-р хороо, Бакула ринбүчийн гудамж 27/3 өөрийн байр	2028.12.14


Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 2023
оны 12 дүгээр сарын 01 -ны
өдрийн 4/007 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт



**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНД АГУУЛАХЫГ НЭМЭЛТЭЭР БҮРТГЭХ
БАЙГУУЛЛАГУУД**

№	Байгууллагын нэр /РД/	Үйл ажиллагааны чиглэл	Агуулахын хаяг байршил
1.	САНЧИР-УНДРАХ ХХК РД: 5177022 9011119108	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	БЗД, 18-р хороо, 13-р хороолол Бриаллиант эмнэлгийн 12 давхарт 1204, 1205, 1206 тоот
2.	ТАВИН-УС ХХК РД: 2541963 9011120054	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	ХУД 9-р хороо 114-р сургуулийн хажууд 82- тоот

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 2023
оны 12 дүгээр сарын 04 -ны
өдрийн 1/217 дугаар тушаалын гуравдугаар
хавсралт



ТӨСӨЛ ДЭМЖИГДЭЭГҮЙ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХГҮЙ БАЙГУУЛЛАГУУД

№	Байгууллагын нэр /РД/	Үйл ажиллагааны чиглэл
1.	ХАНБОГД ОЧИР БУЛГАН ХХК РД- 3622681 1111007119	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх
2.	ЖИ ЮУ МЕДИКАЛ ХХК РД- 6827179 9011836603	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх
3.	АЧУ ЗАНА ФАРМ ХХК РД-8360898 9011852162	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх

----oO----